



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2024 оны 04 сарын 30 өдөр

Дугаар 100

Улаанбаатар хот

Харилцаа холбооны сүлжээний дугаарын
ашиглалтын хугацаа сунгах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалт, Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалт, үйлчилгээг бүртгэхтэй холбогдсон журмын 4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Энэхүү тогтоолын хавсралтад заасан 3 /гурав/ хуулийн этгээдийн харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацааг 2 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа сунгагдсан хуулийн этгээдүүдтэй гэрээ байгуулж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/- д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ГИШҮҮД

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Н.МАНДАХБААТАР

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2024 оны 04 дүгээр сарын 30 -ны өдрийн
100 тоот тогтоолын
Хавсралт

Харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтын хугацаа
сунгах хуулийн этгээдийн жагсаалт

д/д	Хуулийн этгээд /Иргэн/ -ийн нэр	Олгосон дугаар	Хугацаа	Дугаарлалтын зориулалт
1	Эйч Ар талант ХХК	1900-1970	2024.05.18 2026.05.18	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
2	Ширэвгэр ХХК	1800-1932	2024.01.07 2026.01.07	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ
3	Худалдаа хөгжлийн банк ХК	1800-1977	2024.05.05 2026.05.05	Телефон ярианд суурилсан мэдээлэл, лавлах үйлчилгээ